





**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК  
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

<i>Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/</i>				
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>				
<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/</i>	2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2023 оны 06-р сарын 30-ны өдөр			
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	“Монголын цахилгаан холбоо” ХК УБГД:000000376 Үнэт цаасны код:209 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 1, Утас:7010 2248			
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	“Монголын хөрөнгийн бирж” ХК			
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбар			
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	25,870,276			
<i>Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	Бэлтгэсэн: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Оюундэлгэр, Судалгааны мэргэжилтэн Хянасан: Ж.Баасандорж, Инновац бизнес хөгжлийн газрын захирал			
<i>1.</i>	<i>Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>			
	<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>	<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
		<b>ХӨРӨНГӨ</b>		
		Эргэлтийн хөрөнгө	9,373,600,760.26	11,872,655,697.17
		Эргэлтийн бус хөрөнгө	39,666,462,263.24	39,545,305,687.94
		<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>49,040,063,023.50</b>	<b>51,417,961,385.11</b>
		<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
		Богино хугацаат өр төлбөр	8,001,020,843.91	10,210,731,355.75
		Урт хугацаат өр төлбөр	4,370,849,753.20	4,370,849,753.20
		Эзэмшигчдийн өмч	36,668,192,426.39	36,836,380,276.16
		<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>49,040,063,023.50</b>	<b>51,417,961,385.11</b>

		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<i>Орлогын тайлан</i>		<b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>	<b>17,394,684,301.17</b>	<b>8,487,757,731.94</b>
		Борлуулалтын өртөг	(14,343,851,233.06)	(6,935,321,005.85)
		<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>3,050,833,068.11</b>	<b>1,552,436,726.09</b>
		Түрээсийн орлого	704,504,002.98	319,162,205.73
		Хүүний орлого	149,125,182.48	79,893,192.91
		Бусад орлого	487,292,708.78	385,225,681.55
		Борлуулалт, маркетингийн зардал	(1,153,577,454.91)	(503,770,023.45)
		Ерөнхий ба удирдлагын зардал	(2,624,476,664.75)	(1,337,252,853.55)
		Санхүүгийн зардал	(96,295,888.11)	(113,080,948.74)
		Бусад зардал	(561,743,958.54)	(347,836,235.27)
		Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	15,362,389.45	(2,431,959.66)
		Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	63,090,908.27	44,136,363.63
		<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>34,114,293.76</b>	<b>76,482,149.24</b>
		Орлогын татварын зардал	(23,414,254.79)	(3,585,423.09)
		<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>10,700,038.97</b>	<b>72,896,726.15</b>
		<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>		Үзүүлэлт
Өмч	2,587,027,589.00			2,587,027,589.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,247,555,045.10			5,247,555,045.10
Эздийн өмчийн бусад хэсэг	8,247,270,172.39			8,247,270,172.39
Хуримтлагдсан ашиг	20,586,339,619.90			20,754,527,469.67
<b>Нийт дүн</b>	<b>36,668,192,426.39</b>			<b>36,836,380,276.16</b>
<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	6,298,725,977.51	559,441,616.08
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(6,974,488,161.56)	(523,515,797.37)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,501.31)	80,691.35
		<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(675,765,685.36)</b>	<b>36,006,510.06</b>
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	983,774,286.87	308,008,601.51
		<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>308,008,601.51</b>	<b>344,015,111.57</b>
2.	<i>Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцээж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт</i>			
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>			
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Үзүүлэлт	2022.Q4	2023.Q2
Нийт ашгийн хувь		18%	18%	
Цэвэр ашгийн хувь		0.1%	0.9%	
Нийт хөрөнгийн өгөөж ROA		0.0002	0.0014	
Өөрийн хөрөнгийн өгөөж ROE		0.0003	0.0020	

		Үзүүлэлт	2022.Q4	2023.Q2
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа	1.17	1.16
		Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа	0.23	0.18
		Өр төлбөр болон өөрийн хөрөнгө харьцаа	0.34	0.40
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл			
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого			
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/			
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй			
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл			
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.			
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл			
	<p><b>ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ</b></p>  <pre> graph TD     A[ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ХУРАЛ] --&gt; B[ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ]     B --&gt; C[АУДИТЫН ХОРОО]     B --&gt; D[ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО]     B --&gt; E[НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО] </pre> <p><b>Хувьцаа эзэмшигчдийн бүтэц</b>  Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,286 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.</p>			

## Хувьцаа эзэмшигчид



ХУВЬЦААНЫ ТОО

25,870,276

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

4,008

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРАЛ

2023 оны эхний хагас жилийн байдлаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хоёр хурлыг хуралдууллаа.

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдууллаа. Хурлын ирц 24,500,292 ширхэг саналын эрх бүхий 7 хувьцаа эзэмшигч оролцсоноор 94.70441 хувьтай байлаа.

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох тухай
2. Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гаргасан шийдвэрүүд

1. Нэмж гаргах хувьцааны тоо хэмжээ, нэгж үнийг тогтоох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:
  - Компанийн энгийн хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрөв.
  - Компанийн нэмж гаргах энгийн хувьцааны тоо ширхэг, нэгж үнийг компанийн 2022 оны санхүүгийн аудитлагдсан тайланд үндэслэн хууль, тогтоомжид нийцүүлэн тогтоож, саналаа Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д даалгав.
2. Нэмж гаргах хувьцааг одоогийн хувьцаа эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид худалдан авах давуу эрх олгох эсэх тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав. Үүнд:
  - Компанийн хувьцааг эзэмшиж буй хувь хүн, хуулийн этгээдэд нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.
  - Нэмж гаргаж буй энгийн хувьцааны нэгж үнийг тогтоосны дараа хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг хувьцаа эзэмшигч бүрт хүргүүлэх ажлыг холбогдох хууль, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д үүрэг болгов.

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00-14:10 цагт танхимаар болон зайнаас зохион байгуулагдав (Zoom ID: 249 198 1234) URL: [telecommongolia.mn/news/shm2022](https://telecommongolia.mn/news/shm2022).

2023 оны 4 дүгээр сарын 09-ний өдрөөр тасалбар болгон бүртгэсэн 25,870,276 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4,008 хувьцаа эзэмшигчдээс 24,501,420 ширхэг саналын эрх бүхий 18 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.71 хувьтай байлаа. Хурлын даргаар МЦХ ХК-ийн Маркетинг борлуулалтын газрын захирал Содномдовжидын Нямбаяр, хурал зохион байгуулах комиссын даргаар Удирдлага хүний нөөцийн газрын захирал Ч.Цогтгэрэл, гишүүдээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер Ж.Азбаяр нар тус тус ажиллаа.

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлууд

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;

2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
4. 2021 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай;
5. 2022 оны ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, үндэслэлийг танилцуулах тухай
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай

#### **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гаргасан шийдвэрүүд**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар баталж, Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 99.99 хувиар батлав.
  - a. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан С.Цолмон, Ц.Норовжамц, Х.Баянбай нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр тус тус сонгов. Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.
4. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

#### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг (1/3) хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг чөлөөлж, сонгосон бөгөөд, ердийн гишүүн Эрдэнэбулган өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж Б.Төрбат ердийн гишүүнээр түр томилогдсон. Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

#### **ТУЗ-ийн ДАРГА**



**Т.ЛХАГВАСҮРЭН**  
Боомтын сэргэлтийн үндэсний хороо, сайдын ажлын алба

#### **ЕРДИЙН ГИШҮҮД**



**Ч.ЦЭВЭГДОРЖ**  
Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга



**Ж.ЦОГТБАЯР**  
СЯ, СХЭУГ-ын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга



**А.МОЛОР**  
Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газар,  
Төрийн өмчийн удирдлага,  
зохицуулалтын хэлтэс,  
мэргэжилтэн



**М.ЛХАГВАЖАВ**  
Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газар,  
Төрийн өмчийн хяналт,  
шалгалтын хэлтсийн  
мэргэжилтэн



**Б.ТӨРБАТ**  
ЗГ-ийн хэрэг эрхлэх  
газар, Хууль, эрхзүйн  
газар, шинжээч

**ХАРААТ БУС ГИШУУД**



**Ц.НОРОВЖАМЦ**  
Интер аудит ХХК-ийн  
гэрээт аудитор



**Х.БАЯНБАЙ**  
Акпар-Аудит компанийн  
Ерөнхий захирал



**С.ЦОЛМОН**  
Мандах их сургуулийн  
Ахисан түвшний  
сургуулийн захирал

7. *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

*Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:*

Овог, нэр: 1. *Х.Цэцэгмаа*

2. *Т.Бямбасүрэн*

Албан тушаал: 1. *ТУЗ-ийн нарийн бичгийн дарга*

2. *БТА-ны ерөнхий менежер*

Гарын үсэг: .....

*Х.Цэцэгмаа*

*Т.Бямбасүрэн*

2023.10.18